

БАТЛАВ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
..... Д.ГАНЦЭЦЭГ

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2018 оны ...сарын ...ний өдөр

Дугаар \_

Улаанбаатар хот

8061131

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ /цаашид 'Гэрээ' гэх/-г нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид 'Захиалагч' гэх/, түүнийг төлөөлж Эрүүл мэндийн мэдээллийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х. Ганцэцэг, нөгөө талаас Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол, 9-р байр 19 тоотод оршин суух /РД:РЭ73122465/ регистрийн дугаартай Зөөхий овогт Төмөр-Очирын Байгаль /цаашид 'Гүйцэтгэгч' гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээ нь 'Эрүүл мэндийн үзүүлэлт-2017' эмхэтгэл /96 хуудас/-ийг монгол хэлнээс англи хэл рүү орчуулах ажлыг хийж гүйцэтгэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.3 Гэрээгээр гүйцэтгэх орчуулгын ажлыг Гүйцэтгэгч талд хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.
- 1.4 Гэрээгээр гүйцэтгэх орчуулгын ажлын жагсаалтыг энэхүү гэрээнд хавсаргах бөгөөд хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 2.1 Ажлын гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.2-т заасан ажлыг 2018 оны 06-р сарын 11-ний өдрөөс 2018 оны 07-р сарын 03-ны өдөр хүртэл хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. Дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.
  - a. Талууд харилцан тохиролцсоноор.
  - b. Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачлагаар.

### ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС

- 3.1 Энэхүү гэрээний дагуу хийж гүйцэтгэх 1 /нэг/ нүүр орчуулгын хөлсийг 20.000 /хорин мянга/-н төгрөгөөр тооцсон бөгөөд нийт 96 /ерэн зургаа/-н нүүр орчуулгын ажлын хөлс 1.920.000 /нэг сая есөн зуун хорин мянга/-н төгрөг байхаар талууд харилцан тохиролцсон.
- 3.2 Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс ажлын 5 хоногийн дотор ажлын хөлсний 50 хувь буюу 960.000 /есөн зуун жаран мянга/-н төгрөгийг Гүйцэтгэгч талын ХХБ-ны 426011327 дансанд шилжүүлнэ.
- 3.3 Ажлын гүйцэтгэлийг хүлээн авч, гэрээг дүгнэсний эцэст үлдэгдэл 50 хувь буюу 960.000 /есөн зуун жаран мянга/-н төгрөгийг Гүйцэтгэгч талд шилжүүлнэ.

- 3.4 Иргэний хууль болон Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу гэрээт ажлын хөлснөөс НДШ, ХАОАТ-ыг суутган тооцно.

#### **ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ**

- 4.1 Захиалагч нь гэрээний хавсралтанд дурдсан ажлыг төлөвлөгөөнд заасны дагуу буюу 2018 оны 07 дугаар сарын 03-ны дотор ажлын гүйцэтгэлийг хүлээн авч, акт үйлдэн дүгнэх;
- 4.2 Гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлаар мэдээ, мэдээлэл авах, санал, хүсэлт, гомдол гаргах, ажлын чанарт шаардлага тавьж, засвар хийлгэх;
- 4.3 Ажлын явц, гүйцэтгэлийг хянаж, ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг шаардах;
- 4.4 Гүйцэтгэгч талын буруутай үйл ажиллагааны улмаас байгууллагад хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлүүлэх. Гүйцэтгэж буй ажлын чанар доголдлыг арилгуулахаар шаардах;

#### **ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ**

- 5.1 Гэрээний Хавсралтанд дурдсан ажлыг төлөвлөгөөт хугацаанд мэргэжлийн өндөр түвшинд чанартай гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгөх.
- 5.2 Захиалагч талаас шилжүүлсэн бичиг баримт, материал хадгалалт, хамгаалалтыг хариуцаж, ажил үйлчилгээг гүйцэтгэж дууссаны дараа Захиалагч талд буцаан өгөх;
- 5.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг Захиалагч талд нөхөн төлөх;
- 5.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээ, мэдээллийг бусдад ямар нэгэн байдлаар задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээх;
- 5.5 Гэрээний хүчинтэй хугацаанд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ өөр бусад байгууллага, хувь хүн болон гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх;

#### **ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА**

- 4.1 Гэрээний үүрэг хэрэгжих явцад Талуудын хамтын ажиллагааны ёс зүйг эрхэмлэн байгууллагын нэр хүнд болон түүнд хамаарах бусад үнэт зүйлсийг хүндэтгэж ажиллана.
- 6.2 Талууд хамтын ажиллагааны явцад олж авсан нууцад хамаарах аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар хортойгоор буруугаар ашиглах болон гуравдагч этгээдэд задруулахыг хатуу хориглоно.
- 6.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн болон бүтнээр нь биелүүлээгүй, санаатай болон санамсаргүй үйлдсэн буруутай үйл ажиллагаанаас нөгөө талдаа учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд гэрээний нийт үний дүнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.

#### **ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас захиалагч буюу гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийж гүйцэтгэх боломжгүй болбол нэн түрүү нөгөө талдаа бичгээр мэдэгдэж, шаардлагатай хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.

## НАЙМ. БАТАЛГАА

- 8.1 Гэрээний дагуу талуудаас гаргаж өгсөн болон гаргаж өгөх бүх баримт бичиг, мэдээлэл, баталгаа нь үнэн зөв бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болоход зайлшгүй шаардлагатай аливаа чухал нөхцөл байдлыг орхигдуулаагүй болно.

## ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 9.1 Гэрээтэй холбогдон үүсэх аливаа маргаантай асуудлыг талууд эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд ингэх боломжгүй нөхцөл байдал үүсвэл шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

## АРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 10.1 Гэрээ нь талуудын эрх ашиг, сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.
- 10.2 Гэрээ нь талуудын гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба гэрээний зорилго биелснээр буюу гэрээг цуцалснаар дуусгавар болно.
- 10.3 Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр талууд харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.
- 10.4 Аль нэг талын бичгээр ирүүлсэн хүсэлтээр гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр гэрээнд хавсралт байдлаар тусгах бөгөөд эдгээр нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 10.5 Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 10.6 Гэрээ нь адил хүчинтэй хоёр хувь үйлдэгдсэн бөгөөд Талууд тус бүрт нэг нэг хувь хадгалагдана. Талууд гэрээг хувилж тараахыг хориглоно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН


Захиалагчийг төлөөлж

.....  


Х.Ганцэцэг

ЭММА-ны даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гүйцэтгэгчийг төлөөлж

.....  


Т.Байгаль

Хаяг: БЗД-ийн 4 хороо, 15  
хороолол, 9-19 тоот  
/РЭ73122465/

2018 оны ... сарын ... ний өдрийн  
..... дугаартай гэрээний Хавсралт

Эрүүл мэндийн үзүүлэлт 2017 номын орчуулга

№	Эрүүл мэндийн үзүүлэлт бүлэг	Хуудасны тоо	Хүлээлгэн өгөх хугацаа
1	Бүлэг 1. Монгол улсын хүн ам /Өмнөх үг, гарчиг хураангуй/	18	11/VI-12/VI
2	Бүлэг 2. Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтүүд	6	13/VI-14/VI
3	Бүлэг 3. Эх хүүхдийн эрүүл мэнд	10	15/VI-16/VI
4	Бүлэг 4. Эмнэлгийн тусламж үйлчилгээ	11	17/VI-19/VI
5	Бүлэг 5. Эрүүл мэндийн салбарын хүний нөөц	8	20/VI-21/VI
6	Бүлэг 6. Халдварт өвчин	8	22/VI-24/VI
7	Бүлэг 7. Халдварт бус өвчин	11	25/VI-27/VI
8	Бүлэг 8. Хүн амын нас баралт	10	28/VI-30/VI
9	Бүлэг 9. Монгол улсын эм зүйн салбарын үзүүлэлт	5	01/VII
10	Бүлэг 10. Цусны албаны үйл ажиллагаа	3	02/VII
11	Бүлэг 11. Эрүүл мэндийн эдийн засаг	6	03/VII